

ҮСГ-ын даргын 2008 оны 1 дүгээр сарын 18-ны  
өдрийн 01/10 тоот тушаалаар батлав.

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР



# Зочид буудал, зоогийн газрын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

Улаанбаатар хот  
2008 он

# ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

## Нэг. Нийтлэг үндэслэл

Зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон мэдээллийг боловсруулагч, хэрэглэгчдэд статистикийн үзүүлэлтүүдийн тогтолцоо, тэдгээрийн тухай ойлголт, тодорхойлолтыг нэр мөр болгох, мэдээлэл цуглуулах, боловсруулах, түүний үр дүнг статистикийн судалгаа шинжилгээний ажилд ашиглах, нэгдсэн арга зүйг тогтооход энэхүү аргачлалын зорилго оршино.

Зочид буудлын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 3.1-ийн зочид буудал буюу 551 дүгээр бүлгийн 5510-5512 дэд бүлгүүдэд зочид буудалтай холбоотой үйл ажиллагааг хамруулна.

Зоогийн газрын салбарын эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 3.1-ийн зоогийн газар буюу 552 дүгээр бүлгийн 5520-5522 дэд бүлгүүдэд зоогийн газартай холбоотой үйл ажиллагааг хамруулна.

Зочид буудлын үйл ажиллагаа эрхэлж буй зарим аж ахуйн нэгж, байгууллага, иргэд энэхүү үндсэн үйл ажиллагааныхаа зэрэгцээгээр мөн зоогийн газрын үйл ажиллагааг давхар эрхэлж байвал түүнийг үндсэн үйл ажиллагааны дагуу буюу зочид буудлын салбарт хамруулна.

## Хоёр. Ойлголт, тодорхойлолт

Аргачлалд орсон нэр, томъёог дараахь байдлаар ойлгоно (Эх үүсвэр: “Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёо”, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, Улаанбаатар хот, 2004 он; “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага”, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, Улаанбаатар хот, 2005 он). Үүнд:

2.1 Зочид буудал (hotel) гэж хот, бусад суурин газарт байрласан бөгөөд зочид, үйлчлүүлэгчдийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг цогцолборыг;

2.2 Амралтын газар (resort hotel) гэж хот, бусад суурин газар болон түүнээс гадагш байрласан, амралт, чөлөөт цаг өнгөрөөх хэрэгслээр тоноглогдсон үзвэр, үйлчилгээний цогцолборыг;

2.3 Түр хоноглох байр гэж авто буудал, дэн буудлын болон түүнтэй төстэй бусад үйл ажиллагааг;

- Авто буудал (Motel) гэж автозамын дагуу байрласан, зочид, үйлчлүүлэгчдийг хүлээн авч байр, хоол, авто засварын болон бусад үйлчилгээ үзүүлдэг цогцолборыг;
- Дэн буудал (Guest-house) гэж Зочид, үйлчлүүлэгчдийг хүлээн авч байрлуулах, ихэвчлэн өглөөний хоолны үйлчилгээ үзүүлдэг сууц хэлбэрийн байрыг;

2.4. Рашаан сувиллын газар (Spa hotel) гэж эмчилгээний техник хэрэгслээр тоноглогдсон, рашаан сувиллын газрыг;

2.5 Авто сууц (Motor hotel) гэж зочдын унтах, хоол хийх хэрэгслээр тоноглогдсон бүхээг бүхий авто тээврийн хэрэгслийг;

2.6 Нийтийн байр (Dormitory) гэж тодорхой бүлэг хүмүүст зориулагдсан, олон ор бүхий өрөөнүүдтэй нийтийн байрыг (Их дээд сургуулиудын оюутны байрны нэг адил);

2.7 Орон сууцны зочид бүүдал (suite/ apartment hotel) гэж нийтийн орон сууцанд байрласан зочид, үйлчлүүлэгчдийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг газрыг;

2.8 Ресторан гэж нарийн ажиллагаа шаардах олон нэр төрлийн хоол ундаа, түүний дотор нэршсэн болон захиалгат хоолыг технологийн өндөр түвшинд үйлдвэрлэж, хэрэглэгчийн тав тухтай хооллох нөхцлийг хангасан дээд зэргийн үйлчилгээ зохион байгуулдаг хоолны газрыг;

2.9 Кафе гэж хэрэглэгчдийн амралт, чөлөөт цагаа тав тухтай өнгөрүүлэхэд зориулагдсан, гол төлөв зууш, гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн ундаа, цай, кофе, хөөрүүлсэн сүү, халуун шоколад гэх мэт төрөлжсөн болон захиалгат хоол, ундааны зүйлээр үйлчилдэг хоолны газрыг;

2.10 Баар гэж хэрэглэгчдийн амралт, чөлөөт цагаа тав тухтай өнгөрүүлэхэд зориулагдсан, төрөл бүрийн ундаа, шимүүс /коктейль/, хөнгөн зууш, амтат /десерт/-ны зүйлээр үйлчилдэг, гол төлөв өндөр лангуу, босоо сандал, хундага жүнз өлгөх дэгээ, тоногтой дүүжин тааз, үйлчилгээний тохилог танхим, тусгай кабин, намхан жижиг ширээ, сандал, буйдан, хөгжим болон гэрэлтүүлгийн төхөөрөмж, хэрэгсэл бүхий газрыг;

2.11 Гуанз гэж зах зээлийн эрэлт, хэрэглэгчийн онцлог, худалдан авах чадварт тохируулан нарийн ажиллагаа бага шаардах, харьцангуй хямд үнэтэй, нэр төрөл нь өдөр бүр өөрчлөгдөж болох хоол, зууш, халуун, хүйтэн ундаа, ширхэгийн зүйлийг захиалгаар биш урьдчилан хийж хэрэглэгчдийг богино хугацаанд шуурхай үйлчилдэг хоолны газрыг /түргэн хоолны газар/ тус тус ойлгоно.

## Гурав. ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ НЬ

### 3.1 Зочид буудал

3.1.1 Зочид буудал, зэрэглэл. Зочид буудлыг үйлчилгээний чанарын түвшингээр нэгээс таван зэрэглэлээр ангилж “од” (\*)-оор тэмдэглэнэ. Зэрэглэл ахих тутам тавигдах стандартын шаардлага, үйлчилгээний чанарын түвшин дээшилж одны тоо нэмэгдэнэ. Зочид буудлын одны зэрэглэлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Зочид буудлын салбарын улирал, жилийн албан ёсны статистик мэдээллээс энэхүү үзүүлэлтийг тооцох бөгөөд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиргааны статистик мэдээлэл нь уг үзүүлэлтийг шалгах эх үүсвэр болно.

3.1.2 Өрөөний тоо -нд тухайн үйлчилгээний газрын байшин, барилгын зочид, үйлчлүүлэгчдийг хоноход зориулсан өрөө тасалгааг хамруулна. Нийт өрөөний тоог бүх зочид буудлын өрөөний тооны нийлбэрээр гаргана. Нэг буудалд ногдох өрөөний дундаж тоог тооцоход жигнэсэн дунджийг ашиглана.

Нэг зочид буудалд ногдох өрөөний дундаж тоог (1) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$\begin{aligned}\bar{X} &= \text{Нэг зочид буудалд ногдох өрөөний дундаж тоо} \\ X_i &= \text{Зочид буудлын нийт өрөөний тоо} \\ F_i &= \text{Зочид буудлын тоо}\end{aligned}$$

$$\bar{X} = \frac{\sum_{i=1}^M X_i F_i}{\sum_{i=1}^M F_i}; \quad (1)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Улаанбаатар хотод 10 өрөөтэй зэрэглэлгүй энгийн зочид буудал 30; 20 өрөөтэй нэг одтой зочид буудал 50; 30 өрөөтэй хоёр одтой зочид буудал 45; 50 өрөөтэй гурван одтой зочид буудал 20 байна гэж үзье.

Зочид буудлын төрөл	Өрөөний тоо	Зочид буудлын тоо
Энгийн буудал	10	30
1-одтой	20	50
2-одтой	30	45
3-одтой	50	20

Дээрх мэдээг үндэслэн Улаанбаатар хотод нэг зочид буудалд ногдох өрөөний дундаж тоог тодорхойлбол:

$$\bar{X}_a = \frac{\sum_{i=1}^4 X_i F_i}{\sum_{i=1}^4 F_i} = \frac{10 * 30 + 20 * 50 + 30 * 45 + 50 * 20}{30 + 50 + 45 + 20} = \frac{3650}{145} = 25.2$$

Улаанбаатар хотод нэг зочид буудалд дунджаар 25 өрөө ногдож байна.

3.1.3 Үйлчилгээнд бэлэн байгаа орны тоо –нд тухайн үйлчилгээний газрын зочид, үйлчлүүлэгчдийг хоноглоход зориулсан, бүх эд зүйлээр тоноглогдсон, үйлчилгээнд бэлэн байгаа орыг хамруулна.

Нийт орны тоог бүх зочид буудлын орны тооны нийлбэрээр гаргана. Нэг буудалд ногдох орны дундаж тоог тооцоход жигнэсэн дунджийг ашиглана.

Нэг зочид буудалд ногдох орны дундаж тоог (2) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\bar{X}_o$  = Нэг зочид буудалд ногдох орны дундаж тоо

$Y_i$  = Зочид буудлын орны тоо

$F_i$  = Зочид буудлын тоо

$$\bar{X}_o = \frac{\sum_{i=1}^M Y_i F_i}{\sum_{i=1}^M F_i}; \quad (2)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Улаанбаатар хотод 25 ортой зэрэглэлгүй энгийн зочид буудал 30; 30 ортой нэг одтой зочид буудал 50; 40 ортой хоёр одтой зочид буудал 45; 70 ортой гурван одтой зочид буудал 20 байна гэж үзье.

Зочид буудлын төрөл	Орны тоо	Зочид буудлын тоо
Энгийн буудал	25	30
1-одтой	30	50
2-одтой	40	45
3-одтой	70	20

Улаанбаатар хотын нэг зочид буудалд ногдох орны дундаж тоог тодорхойлбол:

$$\bar{X}_o = \frac{\sum_{i=1}^4 Y_i F_i}{\sum_{i=1}^4 F_i} = \frac{25 * 30 + 30 * 50 + 40 * 45 + 70 * 20}{30 + 50 + 45 + 20} = \frac{5450}{145} = 37.6$$

Улаанбаатар хотод нэг зочид буудалд дунджаар 38 ор ногдож байна.

3.1.4 Зочдын нийт ор хоногийн тоо-г тайлант хугацаанд зочид буудалд байрласан зочин тус бүрийн байрласан ор хоногийн тооны нийлбэрээр гаргана.

Тайлант хугацаанд зочдын нийт ор хоногийн тоог тайлант хугацаанд хүлээн авсан нийт зочдын тоонд харьцуулж нэг зочны дундаж ор хоногийг тооцно.

Нэг зочны дундаж ор хоногийг (3) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\bar{X}_{o/\delta}$  = Нэг зочны дундаж ор хоногийн тоо  
 $N$  = Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тоо  
 $H_i$  = Зочдын хоносон хоногийн тоо  
 $E_i$  = Хүлээн авсан зочдын тоо

$$\bar{X}_{i/\delta} = \frac{H}{E} = \frac{\sum_{i=1}^N H_i}{\sum_{i=1}^N E_i} ; \quad (3)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Дараахь Улаанбаатар хотын 2007 оны 3 дугаар улирлын мэдээлэлд үндэслэн аль нэг зочны байрласан дундаж ор хоногийн тоог тодорхойлбол:

Зочид буудлын нэр	Зочдын ор хоногийн тоо	Хүлээн авсан зочдын тоо
Сансар	560	350
Оч	810	400
Мишээл	1150	600
Цэцэг	2480	1200
Хос эрдэнэ	2600	1350

$$\bar{X}_{i/\delta} = \frac{H}{E} = \frac{\sum_{i=1}^N H_i}{\sum_{i=1}^N E_i} = \frac{\sum_{i=1}^5 H_i}{\sum_{i=1}^5 E_i} = \frac{560 + 810 + 1150 + 2480 + 2600}{350 + 400 + 600 + 1200 + 1350} = \frac{7900}{3900} = 2$$

Улаанбаатар хотод 2007 оны 3 дугаар улирлын байдлаар нэг зочны дундаж ор хоног 2 байна.

3.1.5 Хүлээн авсан нийт зочдын тоо -нд цагаар болон бүтэн хоногоор үйлчлүүлснийг үл харгалзан хүлээн авсан бүх зочид орно.

Зочид буудлын салбарт нийт хүлээн авсан зочдын тоог Монгол Улсад байнга оршин суугч болон түр оршин суугч гадаадын зочдын тооны нийлбэрээр гаргана. Монгол улсад түр оршин суугч гадаадын зочдын тоог улсынх нь харьяаллаар гаргана. Зочид, үйлчлүүлэгчдийг дараахь байдлаар ангилна. Үүнд:

- 1) *Монгол Улсад байнга оршин суугч*
  - *Монгол Улсын иргэн*

- Монгол Улсад байнга оршин суугч гадаадын иргэн (183 хоногоос дээш хугацаагаар Монгол Улсад амьдарч байгаа)
- 2) Монгол улсад түр оршин суугч гадаадын иргэн (183 хоногоос хэтрэхгүй хугацаагаар амьдарч байгаа)

Зочид буудлын хүлээн авсан нийт зочдын тоог (4) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$E$  = Хүлээн авсан нийт зочдын тоо  
 $N$  = Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нийт тоо  
 $M_i$  = Монгол Улсын иргэн  
 $B_i$  = Монгол Улсад байнга оршин суугч гадаадын иргэн  
 $T_i$  = Монгол Улсад түр оршин суугч гадаадын иргэн

$$E = \sum_{i=1}^N E_i = \sum_{i=1}^N (M_i + B_i + T_i); \quad (4)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл:

Улаанбаатар хотын зочид буудалд хүлээн авсан зочдын тоо

Зочид буудлын нэр	Монгол Улсад байнга оршин суугч		Монгол Улсад түр оршин суугч гадаадын иргэн	Дүн
	Монгол Улсын иргэн	Монгол улсад байнга оршин суугч гадаадын иргэн		
Сансар	15	20	28	63
Оч	25	28	36	89
Мишээл	30	14	48	92
Цэцэг	45	12	75	132
Хос эрдэнэ	70	8	120	198

Дээрх мэдээг үндэслэн Улаанбаатар хотын зочид буудлын хүлээн авсан нийт зочдын тоог тодорхойлбол:

$$E = \sum_{i=1}^N E_i = \sum_{i=1}^5 (M_i + B_i + T_i) = (15 + 20 + 28) + (25 + 28 + 36) + \dots + (70 + 8 + 120) = 574$$

Улаанбаатар хотын зочид буудалд 574 зочин хүлээн авсан байна.

3.1.6. Үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийн тоо -нд тайлант хугацаанд зочдоод үйлчилгээ үзүүлсэн өдрийн тоог хамруулна.

Тайлант хугацаанд үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийн тоог зочид буудлын тоонд харьцуулж тайлант хугацааны турш үйлчилгээ үзүүлсэн дундаж өдрийн тоог тооцно.

Зочид буудлын үйлчилгээ үзүүлсэн дундаж өдрийн тоог (5) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\bar{X}_{-p}$  = Зочид буудлын үйлчилгээ үзүүлсэн дундаж өдрийн тоо  
 $N$  = Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тоо  
 $U_i$  = Үйлчилгээ үзүүлсэн өдрийн тоо  
 $F_i$  = Зочид буудлын тоо

$$\bar{X}_{-p} = \frac{U}{F} = \frac{\sum_{i=1}^N U_i}{\sum_{i=1}^N F_i}; \quad (5)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Улаанбаатар хотод зочид буудлын 2007 оны 3 дугаар улирлын байдлаар үйлчилгээ үзүүлсэн өдрийн талаарх мэдээлэл ирсэн гэж үзье.

Зочид буудлын нэр	Үйлчилгээ үзүүлсэн өдрийн тоо
Сансар	90
Оч	85
Мишээл	50
Цэцэг	70
Хос эрдэнэ	30

Дээрх мэдээг үндэслэн Улаанбаатар хотын зочид буудлын үйлчилгээ үзүүлсэн дундаж өдрийн тоог тодорхойлбол:

$$\bar{X}_{-p} = \frac{U}{F} = \frac{\sum_{i=1}^5 U_i}{\sum_{i=1}^5 F_i} = \frac{90 + 85 + 50 + 70 + 30}{5} = \frac{325}{5} = 65$$

2007 оны 3 дугаар улирлын байдлаар Улаанбаатар хотод зочид буудлын үйлчилгээ үзүүлсэн дундаж өдрийн тоо 65 байна.

3.1.7. Нэг өдөрт хүлээн авсан зочдын дундаж тоо -г тооцоход тайлант хугацаанд хүлээн авсан нийт зочдын тоог үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийн тоонд хуваана.

Зочид буудлын нэг өдөрт хүлээн авсан зочдын дундаж тоог (6) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\bar{X}_{\zeta/\delta}$  = Зочид буудлын нэг өдөрт хүлээн авсан зочдын дундаж тоо  
 $E_i$  = Хүлээн авсан зочдын тоо  
 $U_i$  = Үйлчилгээ үзүүлсэн өдрийн тоо

$$\bar{X}_{\zeta/\delta} = \frac{E}{U} = \frac{\sum_{i=1}^N E_i}{\sum_{i=1}^N U_i}; \quad (6)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Улаанбаатар хотод зочид буудлын 2007 оны 3 дугаар улирлын байдлаар хүлээн авсан зочин болон үйлчилгээ үзүүлсэн өдрийн талаарх мэдээлэл ирсэн гэж үзье.

Зочид буудлын нэр	Хүлээн авсан зочдын тоо	Үйлчилгээ үзүүлсэн өдрийн тоо
Сансар	350	30
Оч	400	50
Мишээл	600	70
Цэцэг	1200	85
Хос эрдэнэ	1350	90

Дээрх мэдээг үндэслэн Улаанбаатар хотод зочид буудлын нэг өдөрт хүлээн авсан зочдын дундаж тоог тодорхойлбол:

$$\bar{X}_{\text{с/д}} = \frac{E}{U} = \frac{\sum_{i=1}^N E_i}{\sum_{i=1}^N U_i} = \frac{350 + 400 + 600 + 1200 + 1350}{30 + 50 + 70 + 85 + 90} = \frac{3900}{325} = 12$$

2007 оны 3 дугаар улирлын байдлаар Улаанбаатар хотод зочид буудлын нэг өдөрт хүлээн авсан дунджаар 12 зочин байна.

3.1.8. Нийт орлого. Зочид буудлын салбарын нийт орлогод үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны үйлчилгээний орлого орно.

Үндсэн үйл ажиллагааны орлогод зочид буудлын ор хоногийн орлого, буудлын дэргэдэх зоогийн газрын үйлчилгээний орлого, буфетийн худалдааны борлуулалтын орлого, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, зочид буудлын нэмэлт үйлчилгээ (гоо сайхан, үсчин, бассейн, саун, иллэг, интернэт кафе, караоке өрөө гэх мэт)-нээс олсон орлогын нийлбэрээр тооцно.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогод хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэргээс орсон орлого, дээр дурдснаас бусад орлогын нийлбэрээр тооцно.

Зочид буудлын нийт орлогыг улсын дүнгээр болон аймаг, нийслэлээр, зочид буудлын төрлөөр болон зэрэглэлээр ангилан гаргана.

3.1.9 Нэг зочинд ногдох орлого. Тайлант хугацааны үндсэн үйл ажиллагааны орлогын хэмжээг хүлээн авсан зочдын нийт тоонд харьцуулж нэг зочинд ногдох орлогыг тооцно.

Зочид буудлын нэг зочинд ногдох орлогын хэмжээг (7) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$\bar{X}_{\text{г/д}} = \text{Нэг зочинд ногдох орлого}$$

$N$  = Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тоо

$O_i$  = Үндсэн үйл ажиллагааны орлого

$E_i$  = Хүлээн авсан зочдын тоо

$$\bar{X}_{i\delta} = \frac{\hat{I}_-}{E} = \frac{\sum_{i=1}^N O_i}{\sum_{i=1}^N E_i}; \quad (7)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл:

Улаанбаатар хотын зочид буудлын үндсэн үйл ажиллагааны орлого, хүлээн авсан зочдын тоо

Зочид буудлын нэр	Үндсэн үйл ажиллагааны орлого (мян.төг)	Хүлээн авсан зочдын тоо
Сансар	12600	350
Оч	16800	400
Мишээл	26400	600
Цэцэг	54600	1200
Хос эрдэнэ	62800	1350

Дээрх мэдээг үндэслэн Улаанбаатар хотын зочид буудлын нэг зочинд ногдох орлогын хэмжээг тодорхойлбол:

$$\bar{X}_{i\delta} = \frac{\hat{I}_-}{E} = \frac{\sum_{i=1}^5 O_i}{\sum_{i=1}^5 E_i} = \frac{12600 + 16800 + 26400 + 54600 + 62800}{350 + 400 + 600 + 1200 + 1350} = \frac{173200}{3900} = 44.4 \text{ мянган төгрөг}$$

Улаанбаатар хотын зочид буудлын нэг зочинд ногдох орлого 44.4 мянган төгрөг байна.

**3.1.10. Нийт зардал.** Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон гарсан болон үйл ажиллагааны бусад төрлийн зардал (ажиллагчдын үндсэн ба нэмэгдэл цалин, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, тээврийн зардал, зар сурталчилгаа, үндсэн хөрөнгийн элэгдэл гэх мэт)-ын нийлбэрээр зардлын хэмжээг тооцно. Зочид буудлын нийт зардлыг улс, аймаг, нийслэлээр болон зочид буудлын төрлөөр болон зэрэглэлээр гаргана.

**3.1.11 Нэг зочинд ногдох зардал.** Тайлант хугацааны нийт зардлыг тухайн хугацаанд хүлээн авсан зочдын нийт тоонд харьцуулж нэг зочинд ногдох зардлыг тодорхойлно.

Үүнийг томъёогоор (8) илэрхийлбэл:

$\bar{X}_{\zeta\delta}$  = Нэг зочинд ногдох зардал

Z = Нийт зардал

$E_i$  = Хүлээн авсан зочдын тоо

$$\bar{X}_{\text{сэд}} = \frac{Z}{E} = \frac{\sum_{i=1}^N Z_i}{\sum_{i=1}^N E_i} ; \quad (8)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл:

Улаанбаатар хотын зочид буудлын зардал, хүлээн авсан зочдын тоо

Зочид буудлын нэр	Зардал (мян.төг)	Хүлээн авсан зочдын тоо
Сансар	10500	350
Оч	14200	400
Мишээл	22680	600
Цэцэг	48600	1200
Хос эрдэнэ	52800	1350

Дээрх мэдээг үндэслэн Улаанбаатар хотод зочид буудлын нэг зочинд ногдох зардлын хэмжээг тодорхойлбол:

$$\bar{X}_{\text{сэд}} = \frac{Z}{E} = \frac{\sum_{i=1}^5 Z_i}{\sum_{i=1}^5 E_i} = \frac{10500 + 14200 + 22680 + 48600 + 52800}{350 + 400 + 600 + 1200 + 1350} = \frac{148780}{3900} = 38.1 \quad \text{мянган төгрөг}$$

Улаанбаатар хотын зочид буудлын нэг зочинд ногдох зардал 38.1 мянган төгрөг байна.

**Дээрх үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь:**

Зочид буудал, амралтын газар, түр хоноглох байрны хувьд үндсэн үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь зочид буудлын салбарын улирал, жилийн албан ёсны статистик мэдээлэл (“Зочид буудлын үйл ажиллагааны 20.. оны мэдээ”- ЗБ-1, “Зочид буудлын үйл ажиллагааны 20.. оны ... -р улирлын мэдээ”- ЗБ-1а) байна.

**Мэдээлэл цуглуулалт:**

Зочид буудлын үйл ажиллагааны улирал, жилийн мэдээнд бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд мэдээллийг цуглуулна.

### 3.2 Зоогийн газар

3.2.1 Үйлчилгээнд бэлэн байгаа нийт суудлын тоо –нд тухайн зоогийн газрын үйлчлүүлэгчдийг хүлээн авч үйлчлэх бүх суудлын тоо /багтаамж/-г хамруулна.

Үйлчилгээнд бэлэн байгаа нийт суудлын тоог бүх зоогийн газруудын суудлын тооны нийлбэрээр гаргана. Зоогийн газрын нийт суудлын тоог аймаг, нийслэл болон зоогийн газрын төрлөөр гаргана. Нэг зоогийн газарт ногдох үйлчилгээнд бэлэн байгаа суудлын дундаж тоог тооцоход жигнэсэн дунджийг ашиглана.

Нэг зоогийн газарт ногдох үйлчилгээнд бэлэн байгаа суудлын дундаж тоог (9) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\bar{X}_{\bar{N}}$  = Нэг зоогийн газарт ногдох суудлын дундаж тоо

$N$  = Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тоо

$Z_i$  = Зоогийн газрын нийт суудлын тоо

$C_i$  = Зоогийн газрын тоо

$$\bar{X}_{\bar{N}} = \frac{\sum_{i=1}^N Z_i C_i}{\sum_{i=1}^N C_i} ; \quad (9)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Улаанбаатар хотод 25 суудалтай гуанз 30; 30 суудалтай баар 50; 40 суудалтай кафе 45; 70 суудалтай ресторан 20 байж гэж үзье.

Зоогийн газрын төрөл	Суудлын тоо	Зоогийн газрын тоо
Гуанз	25	30
Баар	30	50
Кафе	40	45
Ресторан	70	20

Нэг зоогийн газарт ногдох үйлчилгээнд бэлэн байгаа суудлын тоог тодорхойлбол:

$$\bar{X}_{\bar{N}} = \frac{\sum_{i=1}^N Z_i C_i}{\sum_{i=1}^N C_i} = \frac{\sum_{i=1}^4 Z_i C_i}{\sum_{i=1}^4 C_i} = \frac{25 * 30 + 30 * 50 + 40 * 45 + 70 * 20}{30 + 50 + 45 + 20} = \frac{5450}{145} = 37.6$$

Улаанбаатар хотын нэг зоогийн газарт дунджаар 38 суудал ногдож байна.

3.2.2 Нийт орлого. Зоогийн газрын салбарын нийт орлогод үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны үйлчилгээний орлого орно.

Үндсэн үйл ажиллагааны орлогод хоолны үйлчилгээний орлого, буфетийн худалдсан бүтээгдэхүүний худалдааны борлуулалтын орлого, байр, тоног төхөөрөмжийн түрээснээс орсон орлогын нийлбэрээр тооцно.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогод хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэргээс орсон орлого болон дээр дурдснаас бусад орлогын нийлбэрээр тооцно.

Зоогийн газрын нийт орлогыг улс, аймаг, нийслэлээр болон зоогийн газрын төрлөөр гаргана.

**3.2.3 Нийт зардал.** Зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын хоол, унд хийхтэй холбогдон гарсан болон үйл ажиллагааны бусад төрлийн зардал (ажиллагчдын үндсэн ба нэмэгдэл цалин, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, тээврийн зардал, зар сурталчилгаа, үндсэн хөрөнгийн элэгдэл гэх мэт)-уудын нийлбэрээр зардлын хэмжээг тооцно. Зоогийн газрын нийт зардлыг улс, аймаг, нийслэлээр болон зоогийн газрын төрлөөр гаргана.

**Дээрх үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь:**

Зоогийн газрын салбарын улирал, жилийн албан ёсны статистик мэдээлэл (“Зоогийн газрын үйл ажиллагааны 20.. оны мэдээ”- ЗГ-1, “Зоогийн газрын үйл ажиллагааны 20.. оны ... -р улирлын мэдээ”- ЗГ-1а) нь зоогийн газрын салбарын үндсэн үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр болно.

**Мэдээлэл цуглуулалт:**

Зоогийн газрын үйл ажиллагааны улирлын мэдээнд бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудаас; жилийн мэдээнд аймгийн аж ахуйн нэгж, байгууллагыг бүгдээс нь, Улаанбаатар хотын аж ахуйн нэгж, байгууллагуудыг ажиллагчдын тоогоор нь бүлэглэсэн, санамсаргүй түүврийн аргыг ашиглан сонгож мэдээллийг цуглуулна.

## **Ашигласан материал**

1. Стандарт хэмжил зүйн үндэсний төв. Монгол Улсын Стандарт  
“Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага”  
MSN 4946 : 2005
2. Стандарт хэмжил зүйн үндэсний төв. Монгол Улсын Стандарт  
“Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёо”  
MSN 2004, Ангилалын код 03200
3. Олон улсын үйл ажиллагааны салбарын ангилал- 3.1 (ISIC-3.1)